

**“ГРАНТ ТОРНТОН АУДИТ” ХХК**

Аудит, татвар, зөвлөх үйлчилгээний  
дэлхийн сүлжээний бие даасан фирм

Далай тауэр, 9 давхар,  
ЮНЕСКО гудамж - 31,  
Сүхбаатар дүүрэг,  
1 хороо Улаанбаатар  
14230, Монгол улс  
Т + 976 70 110744  
+ 976 70 110799

Dalai Tower, 9 floor,  
UNESCO street - 31,  
Sukhbaatar District-1,  
Ulaanbaatar 14230,  
Mongolia  
T + 976 70 110744  
+ 976 70 110799

# Хараат бус аудиторын дүгнэлт

**Ард Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:****Дүгнэлт**

Бид Ард Даатгал ХК (цаашид “компани” гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх дараах санхүүгийн тайлангуудад (цаашид “санхүүгийн тайлан” гэх)-д аудит хийлээ. Үүнд:

- Санхүүгийн байдлын тайлан,
- Орлогын дэлгэрэн үйл тайлан,
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан болон
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогын хураангуй,
- Бусад тайлбар тодруулгууд

Бидний дүгнэлтээр, Ард Даатгал ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн эрх бүхий байгууллагын баталсан дүрэм журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт (АОУС)-уудын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулав.

**Хараат бус байдал**

Бид Нягтлан бодогчдын ёс зүйн Олон улсын стандартын зөвлөлийн мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм болон Монгол улсын мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн зохих шаардлагуудын дагуу тус Компаниас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай, зохистой гэж итгэж байна.

### Аудитын аргачлалын хураангуй

- Материаллаг байдал
- Санхүүгийн тайлангийн аудитад ашигласан нийт материаллаг байдал нь 352,319 мянган төгрөг ба материаллаг байдлыг сонгохдоо нийт хөрөнгийн 1%, даатгалын үйлчилгээний цэвэр орлогын 2%-иар тооцсон.
  - Компани нь олон нийтэд хувьцаагаа арилждаг буюу олон нийтийн ашиг сонирхлын компани, мөн ашгийн хувьд өндөр хэлбэлзэлтэй зэрэг шинж чанаруудыг харгалзан нийт хөрөнгө болон даатгалын үйлчилгээний цэвэр орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тус тус сонгосон. Компанийн ажилчдаас авсан асуулгын үр дүн, өмнөх аудитын зөвлөмж, зохицуулагч байгууллагын тайланд үндэслэн эрсдэлийг дундаж гэж үнэлэн хувь хэмжээг 1%, 2%-иар тогтоолоо.

### Онцлох асуудал

"Ард даатгал" ХК нь санхүүгийн тайлангаа Сангийн Сайдын "Даатгалын компаниудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, аргачлал батлах тухай" 2020 оны 07 сарын 07-ны 132 дугаар тогтоолоор батлагдсан заавар, маягт, аргачлалын дагуу бэлтгэж, толилуулсан.

Энэхүү заавар нь СТОУС, НББ-ийн тухай хуульд заасан нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмууд дээр үндэслэсэн бөгөөд дансдын нийтлэг бичилтүүдийг үзүүлж, зааварт тусгагдаагүй зүйлсийг бүртгэхдээ холбогдох СТОУС-ын заалт болон Монгол Улсад мөрдөгдөж буй хууль, дүрэм, журамд бүрэн нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж ажиллахыг шаарддаг.

Компани нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ Санхүүгийн зохицуулах хорооноос батлан гаргасан даатгалын багц дүрмийг тууштай мөрдөнө.

### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-нээрх жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэх ба харин санхүүгийн тайлан болон манай аудиторын тайланг багтаахгүй. Жилийн тайлан нь энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш бидэнд нээлттэй болно.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй бөгөөд бид аливаа хэлбэрээр баталгаажуулалтын дүгнэлт илэрхийлэхгүй.

Санхүүгийн тайланд бидний хийсэн аудиттай холбоотой бидний үүрэг хариуцлага бол дээр тодорхойлсон бусад мэдээлэл бидэнд нээлттэй болсон үед уншиж танилцах, ингэхдээ уг бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар бидний олж авсан мэдлэгтэй материаллаг хэмжээгээр харшилж байгаа эсвэл өөрөөр материаллаг байдлаар буруу илэрхийлэгдсэн эсэхийг авч үзэх юм.

### Удирдлага болон Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн Санхүүгийн тайланд хүлээх үүрэг хариуцлага

Компанийн удирдлага эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэгтэй. Удирдлагын тодорхойлох энэхүү дотоод хяналт нь санхүүгийн тайланг аливаа алдаа эсвэл залилангийн улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай байдаг.

Удирдлага нь санхүүгийн тайланг бэлтгэхдээ Компанийн үйл ажиллагааг зогсоох юм үү татан бүүлгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### *Санхүүгийн тайлагналын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайланг нь бүхэлдээ анги эсэх талаарх үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй.

Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

### *Аудитор нь залилан зэрэг хууль бус асуудлуудыг илрүүлэх чадавхийг ямар цар хүрээнд авч үзсэн талаарх тайлбар*

АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх үзлийг хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

- Залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд санал дүгнэлт өгөх зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулах зорилгоор аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй, байдлыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал Компани тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ, үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад олж илрүүлсэн дотоод хяналтын мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад томоохон асуудлуудаар засаглах орх модол бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн гэдгээ засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг ба мөн бид тэдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл холбогдох хамгаалалт зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлуудаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад чухал асуудлуудыг тодорхойлж тэдгээр асуудлаа аудитын гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайландаа аливаа асуудлаар харилцах нь тухайн харилцаанаас хүртэх олон нийтийн үр өгөөжөөс илүү сөрөг

үр дагавартай учраас аудиторын тайландаа харилцахгүй байх нь зүйтэй гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.

#### **Бусад хууль тогтоомж, зохицуулалтын шаардлагын талаар**

Монгол улсад даатгалын үйл ажиллагааг зохицуулах үндсэн хууль тогтоомж нь Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Жолоочийн даатгалын тухай хууль, СЗХ-ны тогтоолоор батлагдсан даатгалын багц дүрэм, журмууд байна.

Монгол улсын Компанийн тухай хуулийн 92, 94-р зүйлд заасны дагуу сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Сангийн сайдын журам болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон бусад мэдээлэл, Компанийн дүрэмд заасан бусад мэдээллийг тайлагнах үүрэгтэй бөгөөд эдгээр зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

#### **Төлбөрийн чадварын талаар**

Компанийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төлбөрийн чадварын харьцаа 118.65% (2021: 115.97%) байгаа нь Даатгагчийн төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, түүнд хяналт тавих журмын 2.18-д заасан "Даатгагчийн төлбөрийн чадварын зохистой харьцаа нь 110 хувь буюу түүнээс илүү байвал зохино" гэснийг хангасан байна.

#### **Аудитын тайлангийн хэрэглээ**

Энэхүү тайланг "Компанийн тухай" хуулийн 94-р зүйлд заасны дагуу зөвхөн компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулсан ба бусад өөр этгээдэд зориулаагүй болно. Бид энэхүү тайлангийн хүрээнд бусад аливаа нэгэн гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хараат бус аудиторын тайланг гаргахад оролцсон гэрээт ажлын Партнер нь Н.Ордэнзцог болно.



# Санхүүгийн байдлын тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 оны 12 сарын 31- ний үлдэгдэл	2021 оны 12 сарын 31- ний үлдэгдэл
<b>Хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	8	814,417	983,100
Даатгалын авлага	9	5,638,403	3,567,406
Бусад санхүүгийн хөрөнгө	10	752,084	1,712,440
Бусад санхүүгийн бус хөрөнгө	11	548,452	946,715
Хөрөнгө оруулалт	12	24,181,282	23,609,898
Даатгалын хөрөнгө	13	3,091,172	1,924,247
Үндсэн хөрөнгө (цэвэр)	14	405,608	2,082,238
Биет бус хөрөнгө (цэвэр)	15	213,003	-
<b>Нийт хөрөнгө</b>		<b>35,644,511</b>	<b>34,826,044</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмч</b>			
<b>Өр төлбөр</b>			
Даатгалын өглөг	16	2,220,430	2,265,356
Бусад санхүүгийн өр төлбөр	17	694,789	941,160
Бусад санхүүгийн бус өр төлбөр	18	1,345,534	1,515,332
Орлогод тооцоогүй хураамжийн нөөц	19	11,569,702	8,307,000
Нөхөн төлбөрийн нөөц сан	20	3,134,774	3,401,350
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>		<b>18,965,229</b>	<b>16,430,198</b>
<b>Эздийн өмч</b>			
Эзэмшигчдийн өмч	21	5,000,000	5,000,000
Нэмж төлөгдсөн капитал		3,280,854	3,280,854
Дахин үнэлгээний нэмэгдэл		(267,492)	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)		8,665,020	10,114,002
<b>Эздийн өмчийн дүн</b>		<b>16,679,282</b>	<b>18,395,846</b>
<b>Өр төлбөр ба эздийн өмчийн дүн</b>		<b>35,644,511</b>	<b>34,826,044</b>

Уг санхүүгийн байдлын тайланг 2023 оны 3 дугаар сарын 31-нд батлав:



Санхүү удирдлага, үйл ажиллагааны  
газрын захирал  
Т.Батцэнгэл

Огноо: 2023/03/31

Хуудас 13-54-д харуулсан тодруулгууд нь энэхүү санхүүгийн байдлын тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

# Орлогын дэлгэрэнгүй тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
<b>Даатгалын үйл ажиллагаа</b>			
Даатгалын хураамжийн нийт орлого	22.1	22,315,689	16,462,353
Даатгалын хураамжийн буцаалт	22.2	468,805	570,234
Давхар даатгалын хураамжийн зардал	22.3	4,230,922	2,398,880
<b>Даатгалын хураамжийн цэвэр орлого</b>		<b>17,615,962</b>	<b>13,493,239</b>
Орлогод тооцоггүй хураамжийн нөөцийн өөрчлөлт	23	(3,262,702)	(616,900)
Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн өөрчлөлт	24	662,283	(1,183,631)
<b>Орлогод тооцсон хураамж</b>		<b>15,015,543</b>	<b>11,692,708</b>
Нийт нөхөн төлбөрийн зардал	25.1	7,858,896	4,966,724
Давхар даатгагчийн хариуцсан нөхөн төлбөр	25.2	254,590	336,403
Буруутай этгээдийн хариуцсан нөхөн төлбөр	25.3	1,574,204	481,603
<b>Нөхөн төлбөрийн цэвэр зардал</b>		<b>6,030,102</b>	<b>4,140,718</b>
Нөхөн төлбөрийн нөөц сангийн өөрчлөлт	26.1	(244,479)	(4,307)
Нөхөн төлбөрийн нөөц сангийн давхар даатгагчид ногдох хэсгийн өөрчлөлт	26.2	(10,437)	397,693
Учирч болзошгүй хохирлын нөөц сангийн өөрчлөлт	26.3	(22,097)	284,729
<b>Зардалд тооцсон нөхөн төлбөр</b>		<b>5,753,089</b>	<b>4,826,833</b>
Даатгалын гэрээний зардал	27	2,590,349	2,153,743
Давхар даатгалын шимтгэлийн орлого	28	143,467	178,127
Хөрөнгө оруулалтын орлого ба олз (гарз)	29	435,828	9,294,759
<b>Даатгалын үйл ажиллагааны ашиг (алдагдал)</b>		<b>7,251,399</b>	<b>14,185,018</b>
Хүү, эрхийн шимтгэлийн орлого		-	370
Бусад орлого	30	181,590	153,227
Ерөнхий ба удирдлагын зардал	31	2,355,406	2,079,967
Борлуулалт, маркетингийн зардал	32	3,796,194	3,532,465
Саяхүүгийн зардал	33	13,785	41,590
Бусад зардал	34	202,222	485,276
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	35	(226,860)	4,334
Биет болон биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		54,106	98,257
<b>Бусад ашиг (алдагдал)</b>		<b>(6,348,771)</b>	<b>(5,863,110)</b>
<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>		<b>902,628</b>	<b>8,321,908</b>
Орлогын татварын зардал	36	165,973	1,145,928
<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>		<b>736,656</b>	<b>7,175,980</b>

<b>Бусад дэлгэрэнгүй орлого</b>		
Үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	(267,492)	-
<b>Нийт дэлгэрэнгүй орлогын нийт дүн</b>	<b>469,164</b>	<b>7,175,980</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг</b>	<b>0.019</b>	<b>0.29</b>

Хуудас 13-54-д харуулсан тодруулгууд нь энэхүү орлогын дэлгэрэнгүй тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

## Өмчийн өөрчлөлтийн тайлан

Мянган төгрөгөөр	Өмч	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2020 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	5,000,000	3,280,854	-	5,018,128	13,298,982
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(1,079,115)	(1,079,115)
Залруулсан үлдэгдэл	5,000,000	3,280,854	-	3,939,013	12,219,867
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	7,175,980	7,175,980
Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,000,000)	(1,000,000)
2021 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	5,000,000	3,280,854	-	10,114,993	16,395,847
НББ-ийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	(1,185,730)	(1,185,730)
Залруулсан үлдэгдэл	5,000,000	3,280,854	-	8,929,263	17,210,117
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	736,657	736,657
Зарласан ногдол ашиг	-	-	-	(1,000,000)	(1,000,000)
Үнэт цаасны бодит үнэ цэнийн өөрчлөлт	-	-	(267,492)	-	(267,492)
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	5,000,000	3,280,854	(267,492)	8,665,920	16,679,282

Хуудас 13-54-д харуулсан тодруулгууд нь энэхүү өмчийн өөрчлөлтийн тайлангийн салшгүй нэг хэсэг болно.



# Мөнгөн гүйлгээний тайлан

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Мөнгөн орлогын дүн		26,846,330	18,269,052
Даатгалын хураамжийн орлого		20,416,387	14,778,490
Давхар даатгалын нөхөн төлбөр		79,384	-
Бусад мөнгөн орлого		6,350,559	3,490,562
Мөнгөн зарлагын дүн		25,685,417	17,754,044
Ажиллагчдад төлсөн		1,680,673	1,353,791
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн		474,863	413,520
Бараа материал худалдан авахад төлсөн		278,149	137,044
Ашиглалтын зардалд төлсөн		36,795	7,484
Давхар даатгагчид төлсөн давхар даатгалын хураамж		4,732,150	942,490
Үүнээс: Сайн дурын даатгалын		4,927,996	3,153,640
Албан журмын даатгалын		2,408,784	1,152,898
Даатгалын төлөөлөгчийн шимтгэл		1,925,532	1,494,050
Даатгалын зуучлагчид төлсөн төлбөр		1,159,115	763,959
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлүүрт төлсөн		53,726	44,160
Хүүний төлбөрт төлсөн		11,525	2,052
Татварын байгууллагад төлсөн		1,158,830	764,169
Даатгалын төлбөрт төлсөн		32,933	27,417
Бусад мөнгөн зарлага		6,804,346	7,497,362
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>1,160,913</b>	<b>515,008</b>
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Мөнгөн орлогын дүн		6,665,261	8,139,680
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого		0,440,007	0,202,700
Хүлээн авсан хүүний орлого		164,428	1,799,186
Хүлээн авсан ногдол ашиг		53,066	57,726

## Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

Мянган төгрөгөөр	Тодруулга	2022 он	2021 он
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>7,577,826</b>	<b>7,934,082</b>
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		7,942	239,526
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн		7,569,884	7,694,556
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(912,565)</b>	<b>205,698</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Мөнгөн зарлагын дүн</b>		<b>437,789</b>	<b>915,374</b>
Төлсөн ногдол ашиг		437,789	915,374
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>		<b>(437,789)</b>	<b>(915,374)</b>
Валютын ханшийн зөрүү		20,758	1,274
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(168,683)</b>	<b>(193,494)</b>
<b>Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>8</b>	<b>983,100</b>	<b>1,176,594</b>
<b>Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0</b>	<b>814,417</b>	<b>983,100</b>

Хуудас 13- 54-д харуулсан тодруулгууд нь энэхүү мөнгөн гүйлгээний тайлангийн салшгүй нэг хэсэг болно.

# Санхүүгийн тайлангийн тодруулгууд

## 1. Үйл ажиллагааны онцлог, ерөнхий мэдээлэл

"Ард Даатгал" ХК нь 1994 оны 3 дүгээр сарын 22-ний өдөр Монголын анхны хувийн даатгалын компани болж үүсгэн байгуулагдсан.

Компани нь 2018 онд 7,5 сая ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгон үнэт цаасны анхдагч зах зээл дээр арилжаалж, 2018 оны 4 дүгээр сарын 20-нд хувьцаат компанийн хэлбэрт шилжин, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлсэн.

Санхүүгийн зохицуулах хорооны 2007 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн №211 дугаар тогтоолоор ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн ТЗ-201/16 тоот гэрчилгээ авсан.

Компанийн үндсэн үйл ажиллагаа нь ердийн даатгалын үйл ажиллагаа бөгөөд үйл ажиллагаа нь дөөтгөлийн дараах хэлбэрүүдэд ангилагддаг. Үүнд:

1. Гэнэтийн осол, эмчилгээний даатгал
2. Хороогийн даатгал
3. Авто тээврийн хэрэгслийн даатгал
4. Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал
5. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал
6. Хариуцлагын даатгал
7. Барилга угсралтын даатгал
8. Ачааны даатгал
9. Санхүүгийн даатгал
10. Агаарын хөлгийн даатгал
11. Мал амьтдын даатгал
12. Итгэлцлийн даатгал
13. Зээлийн даатгал
14. Газар тариалангийн даатгал зэрэг багтана.

Компани тайлант оны эцсээр 94 ажилтан (2021: 101) байсан.

Компани нь орон нутгийн 20 аймаг, нийслэлийн 4 дүүрэгт нийт 24 салбартайгаар ажиллаж байна.

## 2. Монголын бизнесийн орчин

Монгол Улсын улс төр, эдийн засгийн орчны өөрчлөлт, хууль эрх зүй, татвар, хууль тогтоох тогтолцооны хөгжил тасралтгүй үргэлжлэх шинж чанартай байгаа ба Монгол Улсын эдийн засгийн тогтвортой хөгжил нь эдгээр өөрчлөлтөөс ихээхэн хамаардаг.

Коронавируст халдвар (COVID-19)-ын цар тахалтай холбоотой хямралын дараа Монголын эдийн засаг тогтвортой сэргэх үе шатанд орсон. "COVID-19"-ын халдварын нөхцөл байдлыг аажмаар сайжруулах, төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг өргөжүүлэх зэрэг Монгол улсын Засгийн газраас авч хэрэгжүүлсэн зарим арга хэмжээ нь 2022 оны эдийн засгийн өсөлтөд түлхэц болно гэж үзэж байна. Бизнесийн орчныг сайжруулах, ЖДҮ-ийн санхүүжилтийн хүртээмжийг нэмэгдүүлэх, эдийн засгийг нэн тэргүүнд сэргээн босгож хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн Засгийн газрын хүчин чармайлт, хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх үйл ажиллагааны өргөтгөсөн төлөвлөгөө нь Монголын эдийн засгийн тогтвортой байдал, хөгжилд зохих хувь нэмэр оруулах төлөвтэй байна.

### **3. Ерөнхий мэдээлэл, СТОУС-ын хэрэглээ, тасралтгүй үйл ажиллагааны таамаглал**

Эдгээр санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт ("СТОУС")-д нийцүүлэн 2020 оны 07 дугаар сарын 07-ний өдрийн Сангийн сайдын 132 тоот тушаалаар батлагдсан "Даатгалын компаниудад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, санхүүгийн тайлангийн маягт, тодруулга, аргачлал"-ын дагуу бэлтгэсэн.

Эдгээр зааварт санхүүгийн тайлангуудын хүлээн зөвшөөрөлт болон хэмжилтийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ын дагуу бэлтгэхийг шаарддаг хэдий ч, СТОУС-ын толилуулга болон тодруулгын шаардлагуудыг дагаж мөрддөггүй.

Санхүүгийн тайланг бэлтгэх, даатгалын нөөцийг хүлээн зөвшөөрөх, хэмжих, бүртгэхэд СЗХ-ноос баталсан даатгалын багц дүрмийн дараах журмууд нь дагаж мөрдсөн. Үүнд:

- СЗХ-ны 2019 оны 01 дугаар сарын 09-ний өдрийн 02-р тогтоолоор батлагдсан "Даатгалын багц дүрэм"-ийн хоёрдугаар хавсралт "Даатгагчийн төлбөрийн чадварын үзүүлэлт, түүнд хяналт тавих журам"
- СЗХ-ны 2019 оны 01 дугаар сарын 09-ний өдрийн 02-р тогтоолоор батлагдсан "Даатгалын багц дүрэм"-ийн гуравдугаар хавсралт "Даатгалын нөөц сан, албан журмын даатгалын сан болон бусад санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам"
- СЗХ-ны 2019 оны 01 дугаар сарын 09-ний өдрийн 02-р тогтоолоор батлагдсан "Даатгалын багц дүрэм"-ийн дөрөвдүгээр хавсралт "Даатгалын нөөц санд болон албан журмын даатгалын санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ, түүнийг хөрөнгө оруулалтад байршуулахад тавигдах нөхцөл, шаардлага"

2021 оны 12 дугаар сарын 31-нээр дуусгавар болсон санхүүгийн тайлангууд түүний тодруулгуудыг 2022 оны 3 дугаар сарын 31-ний өдөр байгууллагын удирдлага баталсан. (Тодруулга 45-г харна уу).

#### **Ковид-19-н санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийн ерөнхий үнэлгээ**

Ковидтой холбоотой байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ үүсгэх томоохон үйл явдал, нөхцөл байдалд нөлөөлөхүйц тодорхойгүй байдал байхгүй байна.

#### **Тасралтгүй үйл ажиллагаа**

Эдгээр санхүүгийн тайланг Компани нь тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэсэн.

НББОУС 1-д заасны дагуу удирдлага нь тайлант хугацаанаас хойш багадаа 12 сарын ирээдүйн хугацаанд үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахад эргэлзээ төрүүлэх асуудлууд байгаа эсэхийг үнэлэх шаардлагатай. Ийнхүү үнэлэхдээ одоогийн болон хүлээгдэж буй ашигт ажиллагаа, зээлийн эргэн төлөлтийн хуваарь, боломжит санхүүжилтийн эх үүсвэр болон үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадавх зэрэг өргөн хүрээний хүчин зүйлсийг харгалзан үзнэ.

Компанийн тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ үүсгэх томоохон үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой дараах тодорхойгүй байдал байхгүй байна.

### **4. Шинэ болон өөрчлөлт орсон стандартууд болон хэрэглээний тайлбарууд**

#### **4.1. 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлж эхэлсэн шинэ стандартууд**

2022 оны 1 дүгээр сарын 1-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх мэдэгдлүүд байгаа бөгөөд тэдгээр нь Клинтанын санхүүгийн үйлдлийн Олон Улсын Стандартын шинэ үзүүлэлтээр үйл ажиллагаа

#### 4.2. Хүчин төгөлдөр болоогүй буюу хэрэглэж эхлээгүй стандартууд, стандартын нэмэлт өөрчлөлт болон тайлбарууд

Санхүүгийн тайланг баталсан өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөх хугацаа болоогүй НББОУСЗ-ийн өөрчлөлт оруулсан стандарт болон түүний тайлбарууд байгаа ба Компани нь тэдгээр стандарт болон өөрчлөлтийг урьдчилан мөрдөж эхлээгүй байгаа юм.

Удирдлага нь тухайн бүх өөрчлөлтүүдийг хүчин төгөлдөр болох өдөр эсвэл түүний дараагаар Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусган мөрдөж эхлэхээр төлөвлөж байна.

Удирдлага нь эдгээр стандарт, нэмэлт өөрчлөлтөөс шалтгаалан банкны санхүүгийн тайланд томоохон нөлөө үзүүлэхийг урьдчилан тооцоолоогүй бөгөөд тэдгээрийг доор үзүүлэв (энэ хэсгийг харилцагч бүрийн санхүүгийн тайланд тохируулан өөрчлөх шаардлагатай).

- СТОУС 17 "Даатгалын гэрээ"
- СТОУС 17 "Даатгалын гэрээ"-нд оруулсан нэмэлт өөрчлөлт (СТОУС 17 ба СТОУС 4-д оруулсан нэмэлт өөрчлөлт)
- НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга"-д орсон нэмэлт өөрчлөлт - Өр төлбөрийн богино болон урт хугацааны ангилал
- НББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга"-д орсон нэмэлт өөрчлөлт – НББОУСЗ-өөс 2021 оны 2-р сард НББОУС 1 болон СТОУС-ын практик мэдэгдэл 2 "Материал байдлын талаар үнэлэмж гаргах"-д нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгыг сайжруулах зорилготой юм.
- НББОУС 12 "Орлогын татвар" -т орсон нэмэлт өөрчлөлт - Нэг удаагийн гүйлгээнээс үүссэн хөрөнгө, ер төлбөртэй холбоотой хойшлогдсон татвар
- НББОУС 8 "Нягтлан бодох бүртгэлийн бодлого, НББ-ийн тооцооллын өөрчлөлт ба алдаа"-д орсон нэмэлт өөрчлөлт - 2021 оны 2-р сард НББОУСЗ-өөс НББОУС 8-д нэмэлт өөрчлөлт оруулсан бөгөөд энэ өөрчлөлтөөр тайлагнагч байгууллагууд нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлтөөс хэрхэн ялгах ёстойг илүү тодорхой болгож өгсөн.

### 5. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд

#### 5.1. Бүртгэлийн суурь

Эдгээр санхүүгийн тайланг акрузль сууриар бэлтгэсэн ба үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ, хөрөнгө оруулалт болон тодорхой санхүүгийн хэрэглүүрүүдээс бусад зүйлсийг түүхэн өртгийн сууриар бэлтгэсэн.

#### 5.2. Гадаад валют хөрвүүлэлт

##### Үйл ажиллагааны болон толилуулгын валют

Санхүүгийн тайлангууд нь Монгол төгрөгөөр илэрхийлэгддэг ба толгой компанийн үйл ажиллагааны валюттай ижил юм.

##### Гадаад валютаарх ажил гүйлгээ болон үлдэгдэл

Санхүүгийн тайланг бэлтгэхэд үйл ажиллагааны валютаас бусад валютаарх ажил гүйлгээг ажил гүйлгээ гарсан өдөр Монгол банкнаас зарласан ханшаар бүртгэнэ. Тайланг хугацаа бүрийн эцэст гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн зүйлсийг Монгол банкнаас тайлагналын өдрөөр зарласан ханшийг ашиглан дахин хөрвүүлэх бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-нд төгрөгийн ам.доллартай харьцах ханш 3,444.60 байв. (2021 оны 12 дугаар сарын 31-нд: 1 ам.доллар 2,848.80 төгрөг)

Мөнгөн бус зүйлсийг дахин хөрвүүлэхгүй бөгөөд бодит үнэ цэнэ тодорхойлогдсон өдрийн ханшаар дахин хөрвүүлсэн гадаад валютаар илэрхийлэгдсэн бодит үнэ цэнээр бүртгэсэн мөнгөн бус зүйлсээс бусад мөнгөн бус зүйлсийг ажил гүйлгээ гарсан өдрийн валютын ханшийг ашиглан хөрвүүлсэн түүхэн өртгөөр хэмжинэ.

Мөнгөн зүйлсийг дахин хөрвүүлэх болон төлбөр тооцоо хийхэд үүссэн ханшийн зөрүүг тухайн хугацааны ашиг, алдагдалд багтаана. Мөнгөн бус зүйлсийн хөрвүүлэлтээс үүссэн зөрүүнийн олз, гарзыг шууд өмчид хүлээн зөвшөөрснөөс бусад тохиолдолд бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүг тайлант хугацааны ашиг, алдагдалд багтаана. Тийм мөнгөн бус зүйлсийн хувьд олз, гарзын аливаа ханшийн зөрүүний хэсгийг шууд өмчид хүлээн зөвшөөрнө.

### **5.3. Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгөн гүйлгээний тайлан бэлтгэх зорилгоор Мөнгөтэй адилтгах хөрөнгөнд үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг, хөрвөх чадвар сайтай богино хугацааны хөрөнгө оруулалт зэргийг хамруулдаг. Мөнгөтэй адилтгах хөрөнгийг хөрөнгө оруулалт болон бусад зорилгоос илүү богино хугацаат ер төлбөрийг барагдуулах зорилгоор эзэмшдэг. Хэрэв мөнгөтэй адилтгах хөрөнгийн үнэ цэнийг нь өөрчлөх өчүүхэн бага эрсдэлийг мэдэрдэг, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хувирдаг бол Компани нь хөрөнгө оруулалтыг мөнгөтэй адилтгах хөрөнгөөр ангилна.

### **5.4. Санхүүгийн хэрэглүүр**

#### **Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт**

Компани нь тухайн санхүүгийн хэрэглүүрт хамаарах гэрээний оролцогч тал болсон үед санхүүгийн хөрөнгө, ер төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дах гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгөнд хамаарах бүх бодит эрсдэл, өгөөж шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

#### **Санхүүгийн хөрөнгийн ангилал ба анхдагч хэмжилт**

Компани нь СТОУС 17-г 2023 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжүүлж ахлэхтэй холбоотойгоор СТОУС 9-өөс түр чөлөөлөгдөх ба СТОУС 17 хэрэгжүүлэх хүртэл НББОУС 39-ийг мөрдөнө.

#### **Хүлээн зөвшөөрөлт, анхдагч хэмжилт ба үл хүлээн зөвшөөрөлт**

Компани тухайн санхүүгийн хэрэглүүрийн гэрээний заалтуудын нэг хэсэг болсон үед санхүүгийн хөрөнгө, ер төлбөрийг хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн хөрөнгөөс бий болох мөнгөний урсгал дах гэрээний эрх дуусгавар болоход эсвэл санхүүгийн хөрөнгө ба бүх бодит эрсдэл, шагнал шилжихэд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн ер төлбөрийг барагдуулсан, чөлөөлсөн, хүчингүй болгосон эсвэл хугацаа дууссан үед нь үл хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнээр анхлан хэмжсэн бөгөөд ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр илэрхийлснээс бусад санхүүгийн хөрөнгө, ер төлбөрийг анх бодит үнэ цэнэ дээр ажил гүйлгээний ертгийг нэмсэн дүнгээр хэмжинэ.

#### **Санхүүгийн хөрөнгийн ангилал ба дараа үеийн хэмжилт**

Дараа үеийн хэмжилтийн зорилгоор хейджиин хэрэглүүрээс бусад санхүүгийн хөрөнгө анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр дараах категорит хуваагдана.

- Зээл ба авлага
- Ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө
- Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө
- Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хөрөнгүүд хэрэглүүрийн шинж чанар, зорилгоос шалтгаалан анхдагч хүлээн зөвшөөрөлтөөр өөр өөр категорит ордог. Санхүүгийн хэрэглүүрийн категори нь түүний хэмжилт, санхүүгийн хэрэглүүрийн үр дүнд бий болсон орлого, зарлагыг ашиг, алдагдлаар эсвэл шууд бусад

дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрөх эсэхэд чухал хамааралтай. Компанийн категорилсон санхүүгийн хөрөнгийн хураангуйг Тодруулга 5-аас харна уу.

Компани ерөнхийдөө бүх санхүүгийн хөрөнгөө төлбөр тооцоо хийх өдрийн бүртгэлээр хүлээн зөвшөөрдөг. Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсан эсэх талаарх үнэлгээг ядаж тайлант хугацааны эцэс бүрт хийнэ. Бусад зардалд толилуулсан даатгалын авлагын үнэ цэнийн бууралтаас бусад ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгөтэй холбоотой бүх орлого, зардлыг санхүүгийн зардал, санхүүгийн орлого эсвэл бусад санхүүгийн зүйлсэд толилуулна.

**i. Зээл ба авлага**

Зээл болон авлага нь идэвхтэй зах зээл дээр арилжаалагддаггүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй дериватив бус санхүүгийн хөрөнгө юм. Зээл, авлагад даатгалын ба бусад авлага, гар дээрх бэлэн мөнгө болон банкин дах мөнгө багтана.

*Даатгалын авлага*

Даатгалын авлага нь даатгалын бүтээгдэхүүн борлуулсан, үйлчилгээ үзүүлснээс үүссэн бусдаас авахаар хүлээн зөвшөөрөгдсөн нэхэмжлэх дүн байна. Үүнд: даатгалын хураамжийн авлага, буруутай этгээдээс авах авлага, давхар даатгагчаас авах авлага хамаарна.

Сангийн сайдын 2020 оны 132 тоот тушаалаар батлагдсан Даатгалын компанид мөрдөгдөх нягтлан бодох бүртгэлийн зааврын 3.2 Даатгалын авлага хэсэгт "Үнэ цэнийн бууралтыг тооцох СТОУС-д нийцэх аргачлалыг компани дотооддоо боловсруулж, мөрдөж болно" гэж заасны дагуу авлагын бодит үнэ цэнийн аргыг ашигладаг. Өөрөөр холбөл харилцагчийн тологдоогүй байгаа авлагын хугацаа болон чанарыг үнэлж, авлагын эрсдэлийн сан байгуулдаг байна.

*Бэлэн мөнгө ба банкин дах үлдэгдэл*

Компанийн бэлэн мөнгө ба банкин дах үлдэгдэл нь гар дээрх бэлэн мөнгө, банкин дах дансад болон замд яваа бэлэн мөнгөөс бүрдэнэ.

**ii. Ашиг, алдагдлын дараах бодит үнэ цэнээр бүртгэсэн санхүүгийн хөрөнгө**

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хөрөнгийг худалдах зорилгоор эзэмшиж буй эсвэл анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараа бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг ашиг алдагдлаар тусгадаг гэж ангилна. Уг тодорхойлолтын дагуу хейджийн бүртгэлийн шаардлагыг хангахгүй бүх дериватив санхүүгийн хэрэглүүр энэ категорит багтана.

Дериватив санхүүгийн хэрэглүүрээс үүсч буй аливаа олз, гарз нь бодит үнэ цэнийн өөрчлөлтөд суурилдаг. Уг бодит үнэ цэнийн өөрчлөлтийг идэвхитэй зах зээлийн ажил гүйлгээг, идэвхитэй зах зээл байхгүй бол үнэлгээний аргачлалд ашиглан тодорхойлно.

**iii. Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгө**

Борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнээр хэмжих ба дараа үе дэх өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Борлуулах боломжтой гэж ангилсан санхүүгийн хөрөнгөөс үүссэн олз, гарзыг зөвхөн борлуулагдсан эсвэл тухайн хөрөнгө оруулалтын үнэ цэнэ буурсан үед ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Үнэ цэнэ буурсан тохиолдолд өмнө нь бусад орлогод хүлээн зөвшөөрсөн аливаа алдагдлыг ашиг алдагдалд шилжүүлнэ. Орлогын тайлангийн өмчийн хэрэглүүрт хүлээн зөвшөөрсөн алдагдлыг орлогын тайлангаар дамжуулж буцаахгүй харин өмчийг тохируулна. Дараах үеийн өсөлт нь ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын дараа үүсэх үйл явдалд бодитоор холбогдох боломжтой бол өрийн үнэт цаасны үнэ цэнийн бууралтын дүнд бий болсон өмнөх тайлант хугацааны орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн гарзыг орлогын тайлангаар дамжуулж буцаана.

**iv. Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө**

Гэрээний хугацаа дуустал эзэмших санхүүгийн хөрөнгө нь тогтоосон эсвэл тодорхойлж болох төлбөртэй, тогтоосон дуусах хугацаатай дериватив бус санхүүгийн хөрөнгө бөгөөд арилжааны

банкууд дах хадгаламж үүнд орно. Компанийн удирдлага хөрөнгө оруулалтыг хугацаа нь дуустал эзэмших зорилготой бол түүнийг хугацаа дуустал эзэмших хөрөнгө оруулалтаар ангилна.

Хадгаламжийг дараах үед үр ашигт хүүний арга ашиглан хорогдсон дүнгээр хэмжинэ. Мөн хадгаламжийн үнэ цэнэ буурсан гэсэн бодитой нотолгоо байвал санхүүгийн хөрөнгийг урьдчилан тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ. Хадгаламжийн дансны дүнд гарсан аливаа өөрчлөлтийг ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

#### **Санхүүгийн өр төлбөрийн ангилал ба дараа үеийн хэмжилт**

Компанийн санхүүгийн өр төлбөрт даатгалын ба бусад өглөг орно. Компанийн санхүүгийн өр төлбөрийн категорилсон хураангуйг Тодруулга 5-д харуулав.

##### **i. Зээл ба зээллэг**

Зээлийг түүнтэй холбоотой гаргалтын зардлын цэвэр дүн буюу бодит үнэ цэнээр анхлан хүлээн зөвшөөрнө. Бодит үнэ цэнэ, нэрлэсэн үнэ хоорондын зөрүүг тухайн зээллэгийг эзэмшигчээс авснаас бусад тохиолдолд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Тийм тохиолдолд бодит үнэ цэнэ, нэрлэсэн үнэ хоорондын зөрүүг өмчид нэмэлт капиталаар хүлээн зөвшөөрнө. Анхдагч хүлээн зөвшөөрөлтийн дараагаар зээл ба зээллэг нь өртөг болон үр ашигт хүүгийн сууриарх зээллэгийн хугацааны турш ашиг алдагдалд хүлээн зөвшөөрсөн төлөх үеийн үнийн зөрүүний хамт хорогдлын өртгөөр илэрхийлэгдэнэ. Хөрөнгийн нэг хэсэг болгон капиталжуулсан бэлтгэл шаардлагатай хөрөнгийн худалдан авалт, барилга эсвэл үйлдвэрлэлд шууд холбоотой зээлийн өртгөөс бусад зээллэгтэй холбоотой үүссэн хүү болон бусад зардлыг санхүүгийн зардлын хэсгээр хүлээн зөвшөөрнө.

##### **ii. Даатгалын ба бусад өглөг**

Даатгалын ба бусад өглөгийг бодит үнэ цэнээр, дараа үед хорогдуулсан өртгөөр илэрхийлнэ.

##### *Даатгалын өглөг*

Даатгалын өглөгт даатгалын үйл ажиллагаатай холбоотой өглөгүүд хамаарна. Үүнд: даатгалын хураамжийн буцаалтын өглөг, даатгалын гэрээний шимтгэлийн өглөг, давхар даатгагчид өгөх өглөг хамаарна.

##### *Бусад өглөг*

Бусад өглөгийг бодит үнэ цэнээр, дараа үед хорогдуулсан өртгөөр илэрхийлнэ.

#### **5.5. Бараа материал**

Бараа материалыг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар тайлагнана. Бараа материалын өртөг жинлэсэн дунджийн зарчимд суурилдаг ба бараа материалын худалдан авалтын зардал болон үлдэцийн байршил, нөхцөлд анхдагч холбоотой гэжсэн бүх зардал багтана. Цэвэр боломжит үнэ цэнийг бизнесийн хэвийн ажиллагааны үеийн бараа материалын борлуулах үнээс бараа материалыг иж бүрдэл болгох зардал ба борлуулах зардлыг хасч тооцно.

#### **5.6. Урьдчилж төлсөн зардал/тооцоо**

Тухайн тайлант хугацаанд хамааруулан зардал гэж зөвшөөрч бүртгэхээс өмнө төлбөрийг нь урьдчилж төлсөн зарлагыг санхүүгийн байдлын тайлангийн хөрөнгийн зүйл ангид хамааруулан урьдчилж төлсөн зардал гэж бүртгэнэ. Ийм төрлийн зардлуудыг дараагийн тайлант үеийн холбогдох зардалд нь шингээнэ.

Бараа материал, бусад зүйлсийг худалдан авахаар төлсөн урьдчилгааг урьдчилж төлсөн тооцоонд хамааруулна.

#### **5.7. Даатгалын хөрөнгө**

Даатгалын нөөцийн давхар даатгагчид ногдох хэсгийг тайлагналын өдөр Учирсан боловч мэдэгдээгүй хохирлын нөөц сан (УБМХНС) болон Мэдсэн боловч төлөөгүй хохирлын нөөц сан (МБТХНС)-ийн тайлант хугацаанд давхар даатгагчид ногдох хэсгийг актуарчийн тооцоолсон дүнгээр бүртгэдэг.



Давхар даатгалын хойшлогдсон хураамж нь давхар даатгалын хураамжийн давхар даатгалын гэрээний хугацаатай уялдуулан хувь тэнцүүлэх аргаар тооцоолж тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй хэсэг юм.

Давхар даатгалын хойшлогдсон хураамжийн үлдэгдлийг давхар даатгалын хариуцлага эхэлсэн бөгөөд тайлагналын өдрөөр давхар даатгагчийн даатгалын хариуцлага дуусаагүй байгаа давхар даатгалын гэрээ тус бүрийн хувьд гэрээний үлдэх хугацаанд хувь тэнцүүлэх аргаар тооцдог.

Даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал нь даатгалын гэрээг олж бэлтгэхтэй холбогдон гарсан зардлын тайлант хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрөөгүй хэсэг байдаг.

Тухайлбал зуучлагч болон төлөөлөгчийн даатгалын орлогын шимтгэлийн хойшлогдсон зардал, даатгалын хураамжийн дүнтэй хамааралтай гарсан даатгалын гэрээний хойшлогдсон бусад зардлаас бүрддэг.

#### 5.8. Үндсэн хөрөнгө

Барилга, компьютер, техник хэрэгсэл болон бусад тоног төхөөрөмжийг зэрэг хөрөнгийг ашиглалтын байршилд авч ирэхэд гарсан зардлууд болон тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай гарсан зардлуудыг хамруулан худалдан авсан өртөг эсвэл үйлдвэрлэлийн өртгөөр анхлан бүртгэнэ. Санхүүгийн түрээсийн хөрөнгүүдийг барилга болон компьютер дагалдах хэрэглүүрийн адил бүртгэнэ.

Элэгдлийг хөрөнгө тус бүрийн ашиглах хугацаагаар шулуун шугамын аргаар тооцож, ашиг алдагдлаар тусгана. Хөрөнгийг ашиглах боломжтой болсон үед элэгдүүлж эхэлнэ. Хөрөнгийн ашиглах хугацааг дараах байдлаар тогтооно.

Барилга, байгууламж	- 25 жил
Тээврийн хэрэгсэл	- 6-10 жил
Тавилга, эд хогшил	- 6-10 жил
Компьютер, түүнтэй адилтгах хэрэгсэл	- 2 жил
Бусад	- 3-5 жил

#### 5.9. Түрээс

Оффисийн түрээсийн гэрээг сунгах нөхцөлтэйгээр 1-2,5 жилийн хугацаагаар хийдэг. Компани нь борлуулаад, буцаан түрээслэх нөхцөлтэй хэлцэл хийдэггүй. Бүх түрээсийн гэрээг өөр өөр нөхцөлтэйгээр байгуулсан.

Тухайн гэрээ нь түрээс эсэх, эсвэл түрээсийг агуулсан эсэхийг компани нь уг гэрээ үүссэн өдрөөр үнэлнэ. Хэрэв гэрээ нь төлбөрийн хариуд тухайн тодорхойлсон хөрөнгийн ашиглалтыг хянах эрхийг шилжүүлдэг бол уг гэрээ нь түрээс болно, эсвэл түрээсийг агуулсан байна.

#### Түрээслэгчийн түрээсийн хэмжилт болон хүлээн зөвшөөрөлт

Түрээс эхлэх өдрөөр Компани нь санхүүгийн байдлын тайландаа ашиглах эрхийн хөрөнгө болон түрээс өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Ашиглах эрхийн хөрөнгийг өртгөөр нь хэмжих ба энэ нь түрээсийн өр төлбөрийн анхны хэмжилт, Компанийн зарцуулсан аливаа шууд зардал, түрээсийн хугацааны эцэст хөрөнгийг буулгах, нураахтай холбоотой тооцоолсон зардал болон түрээс эхлэх өдрөөс өмнө хийгдсэн урьдчилгаа төлбөрийн нийлбэр юм.

Компани нь ашиглах эрхийн хөрөнгийг шулуун шугамын аргаар гэрээний нөхцөл болон тухайн хөрөнгийн ашиглах жилийн аль багаар элэгдүүлнэ. Мөн ашиглах эрхийн хөрөнгөнд үнэ цэнэ буурах нөхцөл бүрдсэн бол үнэ цэнийг бүүрүүлнэ.

Түрээс эхлэх өдөр өр төлбөрийг тооцохдоо Компани нь ирээдүйн түрээсийн төлбөрүүдийн өнөөгийн үнэ цэнийг түрээсийн нуугдмал хүүний түвшинг (тодорхойлох боломжгүй бол эзэлийн өсөн нэмэгдэх хүүний түвшинг) ашиглан дискаунтчилан тооцно.

Түрээсийн өр төлбөрийн тооцоололд тогтмол төлбөрүүд, индекс эсвэл ханш дээр суурилсан хувьсах төлбөрүүд, гэрээт хугацааны эцэст төлөх нь тодорхой болсон бусад төлбөрүүд хамаарна.